



# МИК ХОЛДИНГ ХК-ИЙН ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар



## Агуулга

1

Компанийн танилцуулга

2

Бизнесийн үйл ажиллагаа

3

Бизнесийн орчин

4

Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны  
хөтөлбөр ба ИЗББ

5

Тулгарч буй сорилт, хэрэгжүүлэх  
зорилт

6

Компанийн хэтийн төлөвлөгөө






# Компанийн танилцуулга


## Эрхэм зорилго

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган дотоод, гадаадын хөрөнгийн зах зээл дээр борлуулах замаар ипотекийн анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, Монгол Улсын хүн амыг орон сууцаар хангах, цаашид орчин үеийн хот байгуулалтыг эрчимжүүлэхэд чиглэсэн урт хугацаат санхүүжилтийн тогтолцоог бий болгож төлөвшүүлэхэд оршино.

## Зээлжих зэрэглэлийн үнэлгээ



## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2018.06.30)



Хувьцаа эзэмшигч	Эзлэх хувь
Монголбанк	2.0%
Хөгжлийн банк	14.9%
Төрийн банк	2.4%
Голомт банк	5.6%
Капитал банк	8.1%
Капитрон банк	1.0%
Ти Ди Би капитал	7.5%
Улаанбаатар хотын банк	26.1%
Хаан банк	1.0%
Хас банк	1.0%
Худалдаа хөгжлийн банк	9.9%
Чингис хаан банк	0.3%
Бусад	20.1%





# Компанийн онцлох үйл явдал

Монголбанк болон арилжааны 10 банк хамтран МИК ХХК байгуулсан

2006

2007

ХБНГУ-ын Сэргээн Босголт Зээлийн Банкны (KfW) зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Сангийн Яам, Монголбанкт харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав

2008

Монголын Ипотекийн Корпораци IUHF /International Union of Housing Finance/ олон улсын байгууллагад гишүүнээр элсэв.

2009

Санхүүгийн зохицуулах хорооноос Монголын Ипотекийн Корпорацийн анхны бонд гаргах хүсэлтийг бүртгэж, зөвшөөрөл өгөв

2012

Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрээр МИК “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл” авч, “Орон сууцны санхүүжилтийн компани” болов

2013

Монголбанк, “МИК ОССК” ХХК болон арилжааны банкууд хамтран “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн Ерөнхий гэрээ”-г байгуулав

“МИК Актив Нэг ТЗК” ХХК хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргав.



2015

“МИК Холдинг” ХК нь IPO хийн, 37.2 тэрбум төгрөг хөрөнгийн зах зээлээс босгож, хувьцааны бүртгэлийн 1-р ангилалд бүртгэгдлээ. Монголын Ипотекийн Корпораци өргөжиж “МИК Холдинг” ХК группын нэгдэл компани боллоо

2017

2017 оны байдлаар 216 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй болж Хөрөнгийн Биржийн ТОП20 индекст багтлаа.

2017

2018

“МИК ОССК” ХХК нь Олон улсын рейтингийн тэргүүлэх Fitch, Moody’s, S&P агентлагуудаар зээлжих зэрэглэл тогтоолгов

FitchRatings

STANDARD & POOR'S

Moody's INVESTORS SERVICE

**B – Stable B – Stable B3 – Stable**


Азийн тогтмол орлоготой үнэт цаасны 5 дахь удаагийн чуулга уулзалт /AFIS/ зохион байгуулав.

2018



# Анхдагч зах зээл болон хоёрдогч зах зээл

## АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛ :



## ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ :





## ОССК-ийн нийгэм дэх ач холбогдол

ОССК нь ипотекийн зээлийг анхдагч зах зээл буюу банкуудаас худалдан авч тэдгээр зээлийн хөрөнгөөр баталгаажуулан үнэт цаас гаргаж, хөрөнгө оруулагчдад борлуулах үйл ажиллагаа явуулдаг ба энэ нь тасралтгүй үргэлжлэн орон сууцны зээлийн тогтвортой санхүүжилтийг бий болгодог.



Тогтмол санхүүжилт бий болсноор иргэдэд олгох орон сууцны зээлийн нөхцөл илүү таатай, илүү хүртээмжтэй болох боломжтой юм.



## Бизнесийн үйл ажиллагаа

МИК нь орон сууцны зээл олгогч банкуудын хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор ипотекийн зээлийн хөрөнгийн багцыг бэлэн мөнгөөр болон санхүүгийн бусад хэрэгслүүдээр худалдаж авах, арилжих үйл ажиллагаа явуулж байна. Орон сууцны зээлийн хөрөнгийг худалдаж авах хэлцлийг зээлийн хөрөнгийн эрсдэл шилжүүлэх нөхцлөөр нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:



*МИК нь зээлийн хөрөнгөөс орж ирэх өгөөж болон учирч болох эрсдэлийг аль алиныг нь шилжүүлэн авах нөхцөлтэй хэлцэл.*



### Онцлог

- Зээлийн хөрөнгө нь банкны балансаас хасагдан Үнэт цаас гаргагчийн баланс дээр бүртгэгддэг
- Банкуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлдэг
- ЗГ-ын орон сууцны зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээлийн хөрөнгийг худалдан авах үйл ажиллагааг энэ хэлцлийн хүрээнд хийж гүйцэтгэж байна

*Худалдан авсан зээлийн хөрөнгөд эрсдэл учирсан тохиолдолд “Худалдагч тал”-д буюу банкинд тухайн зээлийн хөрөнгийг буцаан худалдах эсхүл өөр зээлийн хөрөнгөөр солих нөхцөлтэй хэлцэл.*

### Онцлог

- Зээлийн хөрөнгө нь банкны балансаас гадуур бүртгэгддэг
- Банкуудын хөрвөх чадварыг нэмэгдүүлдэг
- Худалдан авсан зээлд төлбөрийн зөрчил гарвал дараах 2 сонголтын нэгийг хэрэгжүүлдэг.





# Бизнесийн үйл ажиллагаа



МИК нь орон сууцны ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх зорилгоор бизнесийн үндсэн хоёр загварын дор үйл ажиллагаа явуулдаг.

**Зээлийн хөрөнгийн багц худалдан авалт:** Монгол улсын 14 банкнаас 11 банкт хамтарч ажиллан, буцаах нөхцөлтэй хэлцлийн загвараар ипотекийн зээлийг багцлан худалдан авч, ипотекийн зээлийн хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлдэг.

2018 оны 6 дугаар сарын байдлаар банкуудаас нийт 65 удаагийн буцаах нөхцөлтэй худалдан авалтаар 83.2 тэрбум төгрөгийн багцыг худалдан авсан.

Үүнээс 70 хувийг компанийн өөрийн хөрөнгөөр, 30 хувийг Германы сэргээн босголтын зээлийн банкнаас авсан урт хугацаатай зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн.

**Үнэт цаасжуулалт:** Буцаахгүй нөхцөлтэй хэлцлийн хүрээнд Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд олгосон орон сууцны зээлийг худалдан авч, уг зээлийн багцаас бий болох үр ашиг, эрсдэлийг МИК бүхэлд нь шилжүүлж авснаар зээл олгогч банкуудын хөрөнгийн өгөөж нэмэгдэх, эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтүүд сайжрах ач холбогдолтой.


МИК нь Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2018 оны 6 дугаар сарын байдлаар нийт 15 удаагийн хэлцлээр 66,855 зээлдэгчийн зээлийг багцлан худалдан авч, 3,338.2 тэрбум төгрөгийн Ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ) гаргасан.







# Бизнесийн үйл ажиллагаа





# Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийн хөтөлбөр ба ИЗББ

**Санхүүжилтийн эх үүсвэр**  
МБ-аас банкуудад ипотекийн зээл олгоход зориулж хөнгөлөлттэй эх үүсвэр олгосон.

**ИЗББ гаргах**

Давуу эрхтэй (90%) болон энгийн (10%) ИЗББ гаргаж, Давуу эрхтэй ИЗББ-ээр МБ-аас олгосон ипотекийн зээлийн хөнгөлөлттэй эх үүсвэрийг эргүүлэн төлнө.



**Ипотекийн зээл олгох**

- Ипотекийн зээлийн шалгуур:
- Жилийн 8 хувийн хүүтэй, 360 сар хүртэл хугацаатай
    - Урьдчилгаа 30%
      - ЗҮХ ≤70%
  - Орон сууцны талбай ≤80м<sup>2</sup>
    - ӨОХ ≤ 45

**МИК ОССК**

Шалгуур хангасан ипотекийн зээлийн багцыг дэд хөтөлбөрт оролцогч банкуудаас худалдан авна

**Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийн хөтөлбөрийн санхүүжилт:**

Хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй орон сууцны зээл нь Монголбанкнаас Давуу эрхтэй ИЗББ-ын үндсэн төлбөр болон тухайн оны төсөвт тусгагдсан эх үүсвэрээр санхүүжигдэж байна.





## Хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийн хөтөлбөр ба ИЗББ

### ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХҮҮТЭЙ ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨ

#### Иргэд:

- Бага дунд орлоготой өрхүүдэд ипотекийн зээлийн сарын төлбөрийн дарамт багасаж, иргэд өөрийн үл хөдлөх хөрөнгөтэй болох боломжийг бий болгосон.

#### Банкны салбар:

- Банкны салбарын хөрөнгө, өр төлбөрийн хугацааны зөрүүний эрсдэл багассан
- Банкны салбарын эрсдэлийг тархаан байршуулж, банкинд учирч болзошгүй системийн эрсдэлийг бууруулсан.
- Банкны балансаас гадуурх бүтээгдэхүүний төрөлжилт нэмэгдэж, бүтээгдэхүүн үйлчилгээний орлогын эх үүсвэр нэмэгдсэн

#### Хөрөнгийн зах зээл:

- Ипотекийн хоёрдогч зах зээлд ИЗББ-ыг шинээр нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжсэн.
- Хөрөнгийн зах зээлд ажиллах дотоод боловсон хүчин болон үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхлэгч мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаа, мэдлэг туршлагыг нэмэгдүүлсэн.

#### Барилгын салбар:


- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөгжил болон барилгын салбарын орон сууцны борлуулалтыг нэмэгдүүлсэн.
- Барилгын түүхий эд нийлүүлэгчид болон таваарын үйлдвэрлэлийг шууд бусаар дэмжсэн.





# Багцын шинж чанар

Багцын шинж чанар /2018.06.30/	Үзүүлэлт
Зээлийн хөрөнгийн багцын хэмжээ:	2,660.1 тэрбум төг
Дансдын тоо:	58,268
Зээлийн дундаж хэмжээ:	45.75 сая төг
Ж.Д.Зээлийн хүү(%):	7.94%
Зээлийн үлдэгдэл Ж.Д.Хугацаа:	14.37 жил
Ж.Д Зээл-Үнэлгээний харьцаа:	64.49%
Ж.Д Зээлийн насжилт:	3.68 жил
Сарын тэнцүү төлбөр (дундаж):	513,357 төг
Ж.Д. Өр-орлогын харьцаа:	33.43%
Барьцаа хөрөнгийн байршил:	58,268
- УБ хот	45,207 (78%)
- Хөдөө орон нутаг:	13,061 (22%)






# Санхүүгийн үзүүлэлтүүд


(Тэрбум төгрөгөөр)

	Гүйцэтгэл				
	2014	2015	2016	2017	2018Q2
Цэвэр хүүний орлого	17.3	49.1	79.1	89.7	46.8
Цэвэр ашиг*	12.1	30.4	50.7	59.2	30.8
Орон сууцны зээлийн хөрөнгийн багц	828.7	2,021.3	2,150.9	2,547.9	2,689.3
Нийт хөрөнгө	893.9	2,167.4	2,322.5	2,776.3	2,972.8
ИЗББ	835.6	2,037.5	2,165.6	2,576.0	2,726.5
Өөрийн хөрөнгө	46.3	113.4	135.1	162.5	193.3


Цэвэр хүүний орлого (₮ тэрбум)




Цэвэр ашиг (₮ тэрбум)



Өөрийн хөрөнгө (₮ тэрбум)



Нийт хөрөнгө (₮ их наяд)



\* - МИК Групп компанийн цэвэр ашгийн 94% нь ТЗК-ийн нөөц хөрөнгө байгаа болно. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 23-р зүйлд ТЗК нь хөрөнгө оруулагчид болон бусад этгээдэд төлөх төлбөрүүдийг төлж барагдуулсны дараагаар ТЗК-ийн үлдсэн хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хувь тэнцүүлэн олгоно гэсэн байдаг.







# Санхүүгийн үзүүлэлтүүд

	Гүйцэтгэл				
	2014	2015	2016	2017	2018Q2
<b>Хөрөнгийн бүтэц (нийт хөрөнгөд эзлэх %)</b>					
Мөнгөн хөрөнгө	5.6	5.9	6.7	7.7	4.7
Орон сууцны зээлийн багц	92.7	93.3	92.6	91.8	90.5
Өр төлбөр	94.8	94.8	94.2	94.1	92.5
Өөрийн хөрөнгө	5.2	5.2	5.8	5.9	6.4
Санхүүгийн хөшүүрэг (нийт хөрөнгө/өөрийн хөрөнгө)	17.7	19.2	18.1	17.1	16.2
<b>Ашигт ажиллагааны харьцаа</b>					
Цэвэр хүүний маржин %	2.8	3.2	3.6	3.5	3.4
Нийт хөрөнгийн өгөөж %	1.9	2	2.3	2.3	2.1
Өөрийн хөрөнгийн өгөөж %	34.4	38	40.8	39.8	34.6


ИЗББ гаргалт (₮ тэрбум)




Буцаах нөхцөлтэй багцын худалдан авалт (₮ тэрбум)



Ипотекийн зээлийн багц (₮ их наяд)



ИЗББ (₮ их наяд)





# Бизнесийн орчин

2018 оны хагас жилийн байдлаар Санхүүгийн зах зээлийн 95%-г банкны салбар эзэлж байна.



Банкны салбарын нийт зээлийн хэмжээ 14.5 их наяд төгрөг байгаагаас 29.9%-г ипотекийн зээл эзэлж байсан.



Банкны салбарын нийт ипотекийн зээлийн 76.3% -г хөтөлбөрийн хүрээнд олгогдсон зээл эзэлж байсан.



Банкны салбарын нийт ипотекийн зээлийн 61.6% -г МИК-ийн худалдан авсан зээл эзэлж байсан.




## ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛ

2013 онд Засгийн газрын орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн ба тухайн жилд орон сууцны борлуулалт хоёр дахин нэмэгдсэн.


Хөтөлбөрийн эхний жилүүдэд орон сууцны үнэ эрэлтээс үүдэлтэйгээр өсч, орон сууцны үнийн индекс (ОСҮИ) 2014 онд өмнөх оноос 26 хувиар өссөн байна. Орон сууцны борлуулалт 2015 оноос хойш буурах хандлагатай байсан бол 2018 оны 6 сарын байдлаар ОСҮИ нь 1.05 болж өсөх хандлагатай болсон байна.

Орон сууцны үнийн индекс



Хөтөлбөр эхэлсэн жилээс хойш 2013 онд хамгийн их буюу 38,273 орон сууц борлуулагдсан ба түүний 63%-г ипотекийн зээлээр борлуулсан. 2013-2016 онд нийт борлогдсон орон сууцны 60-аас дээш хувь нь ипотекийн зээлээр борлуулагдаж байсан бол 2017 онд тус үзүүлэлт 44 хувь болж буурсан байна. 2018 оны 6 сарын байдлаар энэхүү үзүүлэлт 39%-тай байна.

Орон сууцны борлуулалтад ипотекийн зээлийн эзлэх хувь





# Орон сууцны эрэлт, нийлүүлэлт

## Улаанбаатар хот дах хүн амын суурьшлын тархалт

2017 оны эцсийн байдлаар Монгол улсын хүн ам 3.2 сая байгаагаас 46.1 хувь нь Улаанбаатар хотын оршин суугч байна. 2012 онд нийслэлийн 317 мянган өрхийн 40.2 хувь нь орон сууцанд, 59.8 нь гэр хороололд амьдарч байсан бол 2017 онд нийслэлийн 386 мянга өрхийн 44.3 хувь нь орон сууцанд, 55.7 хувь нь гэр хороололд амьдарч байна. .

Улаанбаатар хотын өрхийн тоо, орон сууцны төрөл



Эх сурвалж: ҮСХ

## Улаанбаатар хотын шинэ орон сууцны нийлүүлэлт


2018.06 сар	Орон сууцны тоо /мянга/
Захиалга авч буй	31.9
Ашиглалтанд орсон	19.2
Ашиглалтанд ороогүй	12.7
Захиалга аваагүй	28.9
<b>Нийт</b>	<b>60.8</b>

Эх сурвалж: Тэнхлэг зууч

## Зээлийн хөрөнгийн багц дах насны бүтэц

2017 оны эцэст МИК-ийн худалдан авсан ипотекийн зээлийн багцын үндсэн зээлдэгчдийн насны бүтцэд 30-35 насныхан хамгийн их буюу 26.8 хувийг эзэлж байна. Монгол Улсын хүн амын насны бүтцэд 29 хүртэлх насныхан нийт хүн амын 55 хувийг эзэлж байгаа нь ирэх 5-10 жилд ипотекийн зээлийн эрэлт нэмэгдэх хандлагатайг харуулж байна

Нийт хүн ам ба ипотекийн зээлдэгчдийн насны бүтэц (2017.12 сар)



Эх сурвалж: ҮСХ, МИК ОССК

2017 оны судалгаагаар Улаанбаатар хотод орон сууцны эрэлт 33,000 орчим, орон сууцны боломжит нийлүүлэлт 38,000 орчим байгаа бөгөөд ойрын 3 жилийн хугацаанд 5,000 гаруй орон сууцны нийлүүлэлтийн илүүдэлтэй байхаар байна.







## Тулгарч буй сорилт, хэрэгжүүлэх зорилт

### Ипотекийн хоёрдогч зах зээл, ХБҮЦ-ны зах зээлд тулгарч буй сорилтууд

- ХБҮЦ-нд хөрөнгө оруулалт хийх дотоодын хөрөнгө оруулагчид дутмаг, ХБҮЦ-ны талаар ойлголт бага
- Хөрөнгө оруулалтын сан нь 10 жил хүртэл хугацаанд үйл ажиллагаа явуулахаар хуульд заасан байдаг бол ИЗББ-ын хугацаа 30 жил хүртэл
- ЗГҮЦ, ТБҮЦ-тай харьцуулахад ХБҮЦ-ны өрсөлдөх чадвар сул
- ХБҮЦ-ны хөрвөх чадварыг дэмжсэн хоёрдогч зах зээлийн хөгжил сул
- Банкны эх үүсвэрийн хугацаа богино, өртөг өндөр
- Санхүүгийн зах зээлийн 95%-ийг банкны салбар эзэлж байна.

---

### Ипотекийн хоёрдогч зах зээл, ХБҮЦ-ны зах зээлийг хөгжүүлэхэд шаардлагатай хүчин зүйлс

- Урт хугацаат эх үүсвэр байршдаг сангуудаас ХБҮЦ-нд хөрөнгө оруулалт хийх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах:
  - Нийгмийн даатгалын сан
  - Баялгын сан (Хүний хөгжлийн сан, төсвийн тогтворжуулалтын сан)
  - Тэтгэврийн сан (Ирээдүйн тэтгэврийн нөөц сан)
  - Хөрөнгө оруулалтын сан
- ХБҮЦ-ны өрсөлдөх чадварыг сайжруулах:
  - ХБҮЦ-ны хүүгийн орлогын татварт хөнгөлөлт үзүүлэх
  - ХБҮЦ-ны эрсдэлээр жигнэсэн хувь хэмжээг бууруулах
- Санхүүгийн зах зээлийг төрөлжүүлэх, түүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд төрийн бодлогоор дэмжих





### Үндсэн үйл ажиллагаа

- “МИК Актив ТЗК 16-24” ХХК хүртэл үүсгэн байгуулж, ИЗББ гаргах.
- Буцаах нөхцөлтэй багцын худалдан авалт хийх .
- Дотоод эх үүсвэрээр худалдан авсан багцаар баталгаажсан "Барьцаат үнэт цаас" гаргах.

### Шинээр хэрэгжүүлэх ажил

- ХБҮЦ-ны хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах.
- Дотоод болон гадаад зах зээлээс хямд санхүүжилт татах.
- Компанийн нийт хувьцаа эзэмшигчдийн бүтцэд ОУБСБ-уудыг оруулах, компанийн засаглалыг сайжруулах.
- Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд ISO стандартыг нэвтрүүлэх.






## Хариуцлагын мэдэгдэл ба нууцлал

Энэхүү танилцуулгыг “МИК ОССК” ХХК-ийн удирдлагууд баталсан бөгөөд өгөгдсөн мэдээлэл үнэн зөв болохыг хариуцан хүлээн зөвшөөрч байна. “МИК ОССК” ХХК нь үндэслэл бүхий аливаа судалгааг хийсний үндсэн дээр өөрт байгаа мэдээлэлд тулгуурлан энэхүү танилцуулга, тайланд буруу, санаатайгаар орхигдуулсан тэмдэглэл буюу түүнийг бий болгох аливаа алдаатай үйл баримт байхгүй, ноцтой алдаа байхгүй болохыг нотолж байна.

“МИК ОССК” ХХК-ийн зөвшөөрөлгүй болон Монгол Улсын хууль тогтоомжид зааснаас бусад байдлаар энэхүү хэлцлийн танилцуулгыг хэсэгчлэн буюу бүхэлд нь дахин боловсруулах, өөр зорилгоор ашиглах, аливаа төрийн болон зохицуулагч байгууллага, бусад этгээдэд үзүүлэх, өгөх, хуулбарлах, хадгалахыг хориглоно.

Энэхүү “МИК ОССК” ХХК ба барьцаат үнэт цаасны талаарх танилцуулга болон түүний агуулга, түүний тодруулахаар өгсөн аливаа мэдээлэл нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын ISO-IEC 27001:2013 стандартын дагуу боловсруулсан компанийн “Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий журам”-д заасан “маш нууц” ангиллын мэдээлэл бөгөөд хугацаагүйгээр нууцад хамаарна.





Mongolia, Ulaanbaatar 14210, Sukhbaatar District, 1<sup>st</sup> micro district,  
Section 13, Peace Avenue 19, 10<sup>th</sup> floor